



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхжин
Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn
Аудитор: О.Наранбат
Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 07/1180

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төсвийн жил дамнуулан буюу дараа онд хэрэгжүүлэх ажил үйлчилгээний гэрээний төлбөр 80,650.0 мянган төгрөгийг тайлант оны төсвөөс санхүүжүүлж, шууд зардлаар бүртгэсэн;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар хориглосон 151,000.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн;
- Шинжлэх ухааны ажилтны 2 дугаар их хурал болон Инновацын 7 хоног арга хэмжээг зохион байгуулахдаа Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/101 дүгээр тушаалаар баталсан зардлын төсвөөс нийт 132,371.6 мянган төгрөгөөр илүү зардал гаргасан;
- Арга хэмжээ зохион байгуулахдаа Үндэсний шинжлэх ухаан, технологийн санг хариуцсан албан тушаалтантай хамаарал бүхий байгууллагаар ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулж нийт 85,706.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангаас суурь судалгааны 122, улсын захиалгат 28, цөм технологийн 1, зорилтот 1, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн 11, гадаадтай хамтарсан 84, инновацын грант 34, нийт 281 төсөлд 7,565,871.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийт эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийн 2,858,750.0 мянган төгрөг буюу 37.8 хувийг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр олгосон нь тайлант онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилт хойшилж, судалгаа боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө буурах эрсдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	11,091,478,828.59	10,565,147,923.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	434,430.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	434,430.00
31210	Төгрөг	-	434,430.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	434,430.00
33	АВЛАГА	313,905,000.00	191,080,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	310,980,000.00	191,080,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,925,000.00	-
34	УРЬДЧИЛГАА	10,707,924,201.01	10,343,736,497.83
34600	Урьдчилж гарсан зардал	10,707,924,201.01	10,319,403,215.83
34700	Бусад урьдчилгаа	-	24,333,282.00
34710	Урьдчилгаа тооцоо	-	24,333,282.00
34714	Томилолтын урьдчилгаа	-	24,333,282.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,649,627.58	29,896,995.43
35400	Хангамжийн материал	69,649,627.58	29,896,995.43
35410	Бичиг хэргийн материал	9,666,050.00	7,938,919.35
35420	Аж ахуйн материал	2,573,530.54	9,598,021.54
35440	Түлш, шатах тослох материал	6,182,598.54	462,798.54
35470	Бусад хангамжийн материал	51,227,448.50	11,897,256.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	178,942,233.84	215,521,157.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	178,942,233.84	215,521,157.63
39200	Биет хөрөнгө	176,664,525.44	214,946,157.63
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	228,102,759.30	306,219,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(104,181,292.46)	(132,848,171.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,915,567.82	83,566,167.82
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(39,162,027.97)	(49,981,077.83)
39217	Номын фонд	7,989,518.75	7,989,518.75
39300	Биет бус хөрөнгө	2,277,708.40	575,000.00
39301	Програм хангамж	45,110,300.00	45,110,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(44,225,925.00)	(44,535,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,360,000.00	8,360,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл - Бусад биет бус хөрөнгө	(6,966,666.60)	(8,360,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	11,270,421,062.43	10,780,669,080.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	2,925,000.00	292,021.38
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,925,000.00	292,021.38
41300	Өглөг	2,925,000.00	292,021.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	292,021.38
41312	НДШ-ийн өглөг	-	292,021.38
41360	Бусад өглөг	2,925,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,925,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	11,267,496,062.43	10,780,377,059.51
51	Засгийн газрын хувь оролцоо	11,267,496,062.43	10,780,377,059.51
51101	-Төрийн	123,479,820.74	123,479,820.74
51200	Хуримтлагдсан үр дүн	11,144,016,241.69	10,656,897,238.77
51210	Өмнөх үеийн үр дүн	12,589,847,393.69	11,089,116,241.69
51220	Тайлант үеийн үр дүн	(1,445,831,152.00)	(432,219,002.92)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,270,421,062.43	10,780,669,080.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,437,906,978.50	12,608,749,969.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,376,040.00	8,194,809.00
1200	Нийтлэг татварын бус орлого	31,376,040.00	8,194,809.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,194,809.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	8,194,809.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	31,376,040.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,406,530,938.50	12,600,555,160.50
1310	Улсын төсвөөс	13,361,666,253.50	12,538,233,987.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,361,666,253.50	12,538,233,987.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,864,685.00	62,321,173.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,864,685.00	62,321,173.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	14,883,070,630.67	13,032,395,330.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,883,070,630.67	13,032,395,330.19
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,798,683,309.38	12,810,187,458.06
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	497,649,956.40	637,261,068.73
210101	Үндсэн цалин	326,134,285.74	422,590,039.10
210102	Нэмэгдэл	96,921,315.49	104,731,823.49
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	54,381,436.57	76,057,980.84
210104	Урамшуулал	10,785,100.00	33,881,225.30
210105	Гэрээт ажлын цалин	9,427,818.60	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,948,022.28	93,709,671.23
210201	Тэтгэврийн даатгал	43,246,922.54	64,791,139.88
210202	Тэтгэмжийн даатгал	5,063,599.24	7,528,153.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,998,078.85	2,935,123.63
210204	Ажилгүйдлийн даатгал	975,892.61	2,424,570.02
210205	Эрүүл мэндийн даатгал	9,663,529.04	16,030,683.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,235,952.00	238,761,000.00
210304	Байрны түрээс	170,235,952.00	238,761,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	83,311,086.39	77,191,364.65
210401	Бичиг хэрэг	18,972,232.00	11,037,070.00
210402	Тээвэр, шатахуун	31,181,796.62	11,519,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,565,382.01	12,147,023.15
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,591,675.76	14,264,275.00
210408	Бараа материал актласны зардал	-	28,223,196.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	276,300.00
210604	Урсгал засвар	-	276,300.00
2107	Томиллолт, зочны зардал	13,756,000.00	7,684,000.00
210702	Дотоод албан томиллолт	13,756,000.00	7,684,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,836,576,596.80	11,678,597,209.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,818,228,896.80	11,674,713,219.47
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,347,700.00	3,883,990.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,205,695.51	76,706,843.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,243,560.00	-

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	65,723,430.00	12,400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	56,238,705.51	64,306,843.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,387,321.29	222,207,872.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,790,800.00	25,734,387.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25,734,387.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,790,800.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	80,596,521.29	196,473,485.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	194,944,414.13
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,682,740.00	1,529,071.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	71,913,781.29	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(1,445,163,652.17)	(423,645,360.69)
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	667,499.83	8,573,642.23
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	667,499.83	8,573,642.23
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	667,499.83	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - үндсэн хөрөнгө	-	8,573,642.23
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(1,445,831,152.00)	(432,219,002.92)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	13,474,537,193.50	12,673,749,969.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,625,000.00	73,194,809.00
1200	Нийтлэг татварын бус орлого	57,625,000.00	73,194,809.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,625,000.00	73,194,809.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	2,925,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	54,700,000.00	73,194,809.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,416,912,193.50	12,600,555,160.50
1310	Улсын төсвөөс	13,361,666,253.50	12,538,233,987.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,361,666,253.50	12,538,233,987.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,245,940.00	62,321,173.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,245,940.00	62,321,173.50
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	13,474,537,193.50	12,563,856,129.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,474,537,193.50	12,563,856,129.50
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,387,224,872.21	12,341,648,257.37
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	438,926,175.33	637,261,068.73
210101	Үндсэн цалин	247,504,436.39	422,590,039.10
210102	Нэмэгдэл	119,329,170.71	104,731,823.49
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	54,077,436.57	76,057,980.84
210104	Урамшуулал	9,385,144.39	33,881,225.30
210105	Гэрээт ажлын цалин	8,629,987.27	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,884,100.00	93,417,649.85
210201	Тэтгэврийн даатгал	35,961,000.00	64,499,118.50
210202	Тэтгэмжийн даатгал	4,230,500.00	7,528,153.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,384,500.00	2,935,123.63
210204	Ажилгүйдлийн даатгал	846,300.00	2,424,570.02
210205	Эрүүл мэндийн даатгал	8,461,800.00	16,030,683.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,235,952.00	238,761,000.00

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210304	Байрны түрээс	170,235,952.00	238,761,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,779,671.01	43,509,802.50
210401	Бичиг хэрэг	6,975,900.00	8,187,889.35
210402	Тээвэр, шатахуун	6,761,600.00	5,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,535,382.01	12,147,023.15
210404	Ном, хэвлэл	119,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,387,789.00	17,374,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	281,700.00	276,300.00
210604	Урсгал засвар	281,700.00	276,300.00
2107	Томилолт, зочны зардал	13,756,000.00	7,684,000.00
210702	Дотоод албан томилолт	13,756,000.00	7,684,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,621,637,843.87	11,308,338,436.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,615,047,643.87	11,304,366,446.29
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,590,200.00	3,971,990.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,723,430.00	12,400,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	65,723,430.00	12,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,312,321.29	222,207,872.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,790,800.00	25,734,387.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25,734,387.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,790,800.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	83,521,521.29	196,473,485.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	194,944,414.13
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,682,740.00	1,529,071.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	74,838,781.29	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	109,893,840.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	109,459,410.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	109,459,410.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	109,459,410.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	109,459,410.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	(109,459,410.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	434,430.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	434,430.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74	-	12,589,847,393.69	12,713,327,214.43
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,479,820.74	-	12,589,847,393.69	12,713,327,214.43
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,445,831,152.00)	(1,445,831,152.00)
11	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74	-	11,144,016,241.69	11,267,496,062.43
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(54,900,000.00)	(54,900,000.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,479,820.74	-	11,089,116,241.69	11,212,596,062.43
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(432,219,002.92)	(432,219,002.92)
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74	-	10,656,897,238.77	10,780,377,059.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,605,768,900.00	12,416,049,951.87	189,718,948.13	98.49
УРСГАЛ ЗАРДАЛ	12,605,768,900.00	12,416,049,951.87	189,718,948.13	98.49
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,532,571,200.00	12,390,315,564.87	142,255,635.13	98.86
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,236,100.00	637,261,068.73	63,975,031.27	90.88
Үндсэн цалин	470,774,200.00	422,590,039.10	48,184,160.90	89.76
Нэмэгдэл	88,499,100.00	104,731,823.49	-16,232,723.49	118.34
Унаа хоолны хөнгөлөлт	99,449,900.00	76,057,980.84	23,391,919.16	76.48
Урамшуулал	42,512,900.00	33,881,225.30	8,631,674.70	79.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,148,700.00	93,417,649.85	6,731,050.15	93.28
Тэтгэврийн даатгал	64,499,200.00	64,499,118.50	81.5	100
Тэтгэмжийн даатгал	8,912,400.00	7,528,153.93	1,384,246.07	84.47
ҮОМШӨ-ний даатгал	4,456,200.00	2,935,123.63	1,521,076.37	65.87
Ажилгүйдлийн даатгал	4,456,200.00	2,424,570.02	2,031,629.98	54.41
Эрүүл мэндийн даатгал	17,824,700.00	16,030,683.77	1,794,016.23	89.94
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	238,761,000.00	238,761,000.00	-	100
Байрны түрээс	238,761,000.00	238,761,000.00	-	100
Хангамж, бараа материалын зардал	33,946,700.00	33,946,700.00	-	100
Бичиг хэрэг	6,102,600.00	5,687,889.35	414,710.65	93.2
Тээвэр, шатахуун	834,500.00	-	834,500.00	-

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,206,900.00	10,883,920.65	-1,677,020.65	118.21
Ном, хэвлэл	257,200.00	-	257,200.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,545,500.00	17,374,890.00	170,610.00	99.03
Эд хогшил, урсгал засварын зардал	276,300.00	276,300.00	-	100
Урсгал засвар	276,300.00	276,300.00	-	100
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	11,439,550,900.00	11,386,652,846.29	52,898,053.71	99.54
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,433,085,900.00	11,382,680,856.29	50,405,043.71	99.56
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,465,000.00	3,971,990.00	2,493,010.00	61.44
Бараа үйлчилгээний бусад зардал	18,651,500.00	-	18,651,500.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,651,500.00	-	18,651,500.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,197,700.00	25,734,387.00	47,463,313.00	35.16
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,819,200.00	25,734,387.00	47,084,813.00	35.34
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	378,500.00	-	378,500.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,605,768,900.00	12,416,049,951.87	189,718,948.13	98.49
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,605,768,900.00	12,416,049,951.87	189,718,948.13	98.49
Улсын төсвөөс санхүүжих	12,605,768,900.00	12,416,049,951.87	189,718,948.13	98.49
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	434,430.00	434,430.00	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
Төсвийн байгууллага	1	1	-	100
АЖИЛЛАГСДЫН ТОО	24	24	-	100
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	22	22	-	100
Үйлчлэх ажилтан	1	1	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	-	62,321,173.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	62,321,173.50
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	60,792,102.50
2104	Хангамж, бараа материалын зардал	-	9,563,102.50
210401	Бичиг хэрэг	-	2,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	5,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,263,102.50
2107	Томилолт, зочны зардал	-	7,684,000.00
210702	Дотоод албан томилолт	-	7,684,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	31,145,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	31,145,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,400,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	12,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,529,071.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,529,071.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,529,071.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	-	62,321,173.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	62,321,173.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	62,321,173.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	62,321,173.50

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 17,480.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Урьдчилж олгосон төслийн санхүүжилтийн зардлыг хаахдаа сөрөг бичилт буюу зардал бууруулж, авлага нэмэгдүүлсэн бичилт хийсэн.	1	17,480.0			1	17,480.0	1	17,480.0				
Дүн	1	17,480.0	-	-	1	17,480.0	1	17,480.0	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар нийт 589,192.5 мянган төгрөгийн 11 зөрчил² илэрснээс, 24,999.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 546,333.1 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 17,859.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн. .

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
БШУС-ын 2024 оны А/24 дүгээр тушаалаар гадаад албан томилолтын зардлыг батлахдаа 1 хүний 11,576.4 мянган төгрөгөөр баталж, санхүүжилт олгохдоо 666.6 мянган төгрөг илүү олгосон байна.	1	666.6	1	666.6								
МУТШСБЭЗХС-ын 2024 оны А/15, А/54 дүгээр тушаалаар гадаад албан томилолтоор ажиллуулах зардлыг баталж, 24,333.3 мянган төгрөгийн томилолтын зардал санхүүжүүлсэн байна. Гэвч томилолт цуцлагдаж, хэзээ явах нь тодорхойгүй байгааг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн байна.	1	24,333.3	1	24,333.3								
Төсвийн жил дамнуулан буюу дараа онд хэрэгжүүлэх ажил үйлчилгээний гэрээний төлбөрийг тайлант оны төсвөөс санхүүжүүлж, шууд зардлаар бүртгэсэн байна. Үүнд: -Орон нутгийн шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааг дэмжин сурталчлах ажлын хүрээнд видео контент, рийл, мэдээлэл бэлтгэх ажил, үйлчилгээний 53,500.0 мянган төгрөгийн гэрээг 8 аж ахуйн нэгжтэй байгуулж, 48,150.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон; -Төслийн сонгон шалгаруулалт, төслийн үйл ажиллагааны санхүүжилтэд судалгаа дүн	1	80,650.0			1	80,650.0						

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

шинжилгээ хийх 15,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилт олгосон; -Судлаачдын бүртгэл, мэдээллийн сан бий болгох, бүртгэлжүүлэх 17,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилт олгосон байна.												
ШУТС-ийн захирлын 2024 оны А/16 дугаар тушаалаар баталсан “Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацийг нутагшуулъя” арга хэмжээний хүрээнд 2 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй ажил, үйлчилгээнд нийт 38,760.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.	1	38,760.0			1	38,760.0						
Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: -БШУС-ын 2024 оны А/244 дүгээр тушаалаар Шилдэг өгүүлэл нийтлүүлсэн судлаачдад нийт 51,000.0 мянган төгрөгийн урамшуулал; -МУТШСБЭЗХС-ын 2024 оны А/61 дүгээр тушаалаар Эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл хэвлүүлсэн судлаачдад нийт 100,000.0 мянган төгрөгийн урамшуулал тус тус олгосон байна.	1	151,000.0			1	151,000.0						
Шинжлэх ухааны ажилтны 2 дугаар их хурал болон Инновацын 7 хоног арга хэмжээг зохион байгуулахдаа БШУС-ын 2024 оны А/101 дүгээр тушаалаар баталсан зардлын төсвөөс нийт 132,371.6 мянган төгрөгөөр илүү зардал гаргасан байна. Тус 2 арга хэмжээний хүрээнд дараах үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: -Бэлэг дурсгалын зүйлд 97,940.0 мянган төгрөг; - Видео шторк, контент хийлгүүлэхэд 37,000.0 мянган төгрөг; -Хүлээн авалтын арга хэмжээ зохион байгуулахад 120,000.0 мянган төгрөг; -Соёл урлагийн арга хэмжээнд 35,000.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.	1	132,371.6			1	132,371.6						
Тайлант онд үр ашиггүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй дараах зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: -ASPA 2024 арга хэмжээг зохион байгуулахдаа 1	1	56,315.5			1	56,315.5						

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

аж ахуйн нэгжээр 9,500.0 мянган төгрөгийн 15 минутын слайд, хувь хүнээр 10,000.0 мянган төгрөгийн вэб хуудас; -Нэр бүхий байгууллагаар 11,290.5 мянган төгрөгийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй; -Зохион бүтээгч, инноваторуудын анхдугаар чуулган болон Шинжлэх ухааны ажилтны өдөр арга хэмжээг зохион байгуулахдаа 25,525.0 мянган төгрөгийн үр ашиггүй, бэлэг дурсгалын зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.												
Арга хэмжээ зохион байгуулахдаа Үндэсний шинжлэх ухаан, технологийн санг хариуцсан албан тушаалтантай хамаарал бүхий байгууллагаар ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулж нийт 85,706.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.	1	85,706.0			1	85,706.0						
МУТШСБЭЗХС-ын 2024 оны А/27, А/28 дугаар тушаалаар гадаад албан томилолтын зардлыг батлахдаа Сангийн сайдын 2011 оны "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 дугаар тушаалаар баталсан зардалд тусгагдаагүй 1,530.0 мянган төгрөгийн уулзалтын заалны түрээсийн зардал төсөвлөж, олгосон байна.	1	1,530.0			1	1,530.0						
Нэг жилийн хугацаатай лицензийн төлбөрийн тайлант онд ногдохгүй 14,389.5 мянган төгрөгийн зардлыг шууд зардлаар бүртгэсэн байна.	1	14,389.5					1	14,389.5				
Бараа, ажил үйлчилгээний нэхэмжлэхийг бөөн дүнгээр хүлээн авсан, нийлүүлэгч байгууллагаас зарлагын баримт хүлээн аваагүй, ямар ажил үйлчилгээ, бараа материал худалдан авсан нь тодорхойгүй ажил, гүйлгээнүүд байна.	1	3,470.0					1	3,470.0				
Дүн	11	589,192.5	2	24,999.9	7	546,333.1	2	17,859.5	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш 541,606.6 мянган төгрөгийн 21 зарлагын гүйлгээ байршуулаагүй байна.	1	-					1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, архивын өрөө нь Архивын албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандартад нийцээгүй байна.	1	-			1	-		
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Нийт дүн	2	-	-	-	1	-	1	-